



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/73/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Д.Цэцэгмаа Утас: 88089024      Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.com Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	---

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ /эх хувь/ .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан .....	13
3.1 Ерөнхий зүйл .....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.1 Төлбөрийн акт .....	18
4.2. Залруулсан алдаа .....	18
4.2 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101

Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/83

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАГ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА О.ГЭРЭЛЧИМЭГ ТАНАА

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>28,343,269.63</u></b>	<b><u>223,579,818.79</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	140,222.13	180,195,155.30
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	66,242.13	426,543.80
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	178,290,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	73,980.00	1,478,611.50
3351	Байгууллагаас авах авлага	73,980.00	1,478,611.50
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	28,203,047.50	43,384,663.49
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	7,257,491.31	23,589,814.41
35110	Тусгай зориулалттай материал	4,835,979.31	14,928,982.21
35130	Эм боох материал	2,421,512.00	8,660,832.20
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	20,945,556.19	19,794,849.08
35410	Бичиг хэргийн материал	144,500.00	811,450.00
35420	Аж ахуйн материал	12,464,406.19	10,302,579.08
35440	Түлш, шатах тослох материал	800,000.00	00.00
35460	Хүнсний материал	845,150.00	1,674,200.00
35470	Бусад хангамжийн материал	6,691,500.00	7,006,620.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>854,150,076.49</u></b>	<b><u>921,546,292.59</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	854,150,076.49	921,546,292.59
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	840,584,076.49	907,980,292.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	840,805,657.00	880,729,957.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-44,646,759.60	-61,389,294.45
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,800,000.00	34,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-8,363,875.03	-12,478,375.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	98,517,283.31	149,365,271.53
39206	Хуримтлагдсан элэгдэл	-86,533,808.44	-88,741,987.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,918,289.00	13,368,289.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,037,709.75	-8,098,568.12
39217	Ном	125,000.00	425,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	13,566,000.00	13,566,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	13,566,000.00	13,566,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>882,493,346.12</u></b>	<b><u>1,145,126,111.38</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>5,797,735.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	5,797,735.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	5,797,735.00	00.00

**Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,797,735.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>876,695,611.12</b>	<b>1,145,126,111.38</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	876,695,611.12	1,145,126,111.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	190,149,470.50	190,149,470.50
51101	Өмч: - төрийн	190,149,470.50	190,149,470.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	107,348,006.56	375,778,506.82
51210	Өмнөх үеийн үр дүн	107,348,006.56	107,348,006.56
51220	Тайлант үеийн үр дүн	0,00	268,430,500.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	579,198,134.06	579,198,134.06
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>882,493,346.12</b>	<b>1,145,126,111.38</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

СТ-2А

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>418,623,500.57</b>	<b>907,943,714.84</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>20,822,246.57</b>	<b>111,190,103.02</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	20,822,246.57	111,190,103.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,822,246.57	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	20,822,246.57	00.00
<b>120017</b>	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ		<b>86,583,838.22</b>
<b>120018</b>	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ		<b>24,606,264.80</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>397,801,254.00</b>	<b>796,753,611.82</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	336,448,400.00	411,183,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	336,448,400.00	411,183,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	5,858,234.00	333,544,880.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,940,134.00	53,459,880.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,918,100.00	00.00
<b>131107</b>	<b>нэмэлт</b>		280,085,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	36,416,000.00	37,323,291.82
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,416,000.00	37,323,291.82
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	19,078,620.00	14,702,140.00

**Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,078,620.00	14,702,140.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>435,664,637.34</b>	<b>627,788,467.27</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	425,886,618.09	626,710,517.71
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	265,175,356.15	298,332,723.80
210101	Үндсэн цалин	191,144,000.00	188,656,900.00
210102	Нэмэгдэл	55,165,359.40	78,783,501.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	4,221,214.60
210104	Урамшуулал	18,865,996.75	26,671,107.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,860,768.00	39,194,338.19
210201	Тэтгэврийн даатгал	23,833,595.00	28,739,596.26
210202	Тэтгэмжийн даатгал	2,359,229.00	2,743,081.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,906,464.00	1,802,642.73
210204	Ажилгүйдлийн даатгал	496,821.00	601,794.79
210205	Эрүүл мэндийн даатгал	5,264,659.00	5,307,222.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,409,655.00	36,823,291.82
210301	Гэрэл, цахилгаан	1,951,551.00	2,101,061.82
210302	Түлш, халаалт	32,365,004.00	34,522,730.00
210303	Цэвэр, бохир ус	93,100.00	199,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,415,370.18	34,026,053.10
210401	Бичиг хэрэг	1,190,550.00	1,452,950.00
210402	Тээвэр, шатахуун	17,912,620.18	22,507,978.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,395,900.00	1,541,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,524,300.00	8,523,325.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	392,000.00	00.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	8,880,276.07	11,724,747.31
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	26,652,478.00	47,017,658.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,177,463.00	37,112,738.50
210502	Хоол, хүнс	7,545,015.00	9,904,920.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,930,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	370,000.00	2,745,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	160,000.00	00.00
210604	Урсгал засвар	210,000.00	2,745,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,456,000.00	506,000.00
210702	Дотоод албан томилолт	1,456,000.00	506,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	429,700.00	136,193,245.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,700.00	135,743,245.18
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	450,000.00

**Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	41,117,290.76	31,871,407.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,917,316.00	7,745,335.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,199,974.76	24,126,072.12
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	9,778,019.25	1,077,949.56
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,029,534.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,029,534.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,796,345.00	43.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,796,345.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,952,140.25	1,077,906.34
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,952,140.25	1,077,906.34
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-17,041,136.77</b>	<b>280,155,247.57</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	8,880,276.07	11,724,747.31
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-8,880,276.07	-11,724,747.31
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-25,921,412.84</b>	<b>268,430,500.26</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

СТ-2А

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>397,801,254.00</b>	<b>618,463,611.82</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>397,801,254.00</b>	<b>618,463,611.82</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	336,448,400.00	411,183,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	5,858,234.00	155,254,880.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,940,134.00	53,459,880.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,918,100.00	00.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	00.00	101,795,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	36,416,000.00	37,323,291.82

**Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,416,000.00	37,323,291.82
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	19,078,620.00	14,702,140.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,078,620.00	14,702,140.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>394,782,454.00</b>	<b>618,463,611.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>394,782,454.00</b>	<b>618,463,611.82</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>385,004,434.75</b>	<b>617,385,662.26</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	265,526,796.75	298,693,025.47
210101	Үндсэн цалин	191,144,000.00	188,656,900.00
210102	Нэмэгдэл	55,516,800.00	79,143,803.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	4,221,214.60
210104	Урамшуулал	18,865,996.75	26,671,107.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,860,768.00	39,194,338.19
210201	Тэтгэврийн даатгал	23,833,595.00	28,739,596.26
210202	Тэтгэмжийн даатгал	2,359,229.00	2,743,081.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,906,464.00	1,802,642.73
210204	Ажилгүйдлийн даатгал	496,821.00	601,794.79
210205	Эрүүл мэндийн даатгал	5,264,659.00	5,307,222.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,409,655.00	36,823,291.82
210301	Гэрэл, цахилгаан	1,951,551.00	2,101,061.82
210302	Түлш, халаалт	32,365,004.00	34,522,730.00
210303	Цэвэр, бохир ус	93,100.00	199,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,456,250.00	29,759,925.00
210401	Бичиг хэрэг	1,197,550.00	2,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,571,700.00	22,271,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,395,900.00	1,541,800.00
210404	Ном, хэвлэл	00.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,376,100.00	2,497,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	915,000.00	949,025.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	19,562,665.00	45,415,790.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,379,665.00	36,639,490.00
210502	Хоол, хүнс	6,253,000.00	6,266,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,930,000.00	2,510,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	530,000.00	4,817,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	320,000.00	2,817,800.00
210604	Урсгал засвар	210,000.00	1,999,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,456,000.00	506,000.00
210702	Дотоод албан томилолт	1,456,000.00	506,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	429,700.00	155,704,836.78

**Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,700.00	155,254,836.78
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,772,600.00</b>	<b>6,471,355.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,772,600.00	6,471,355.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,778,019.25</b>	<b>1,077,949.56</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,029,534.00</b>	<b>00.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,029,534.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,796,345.00</b>	<b>43.22</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,796,345.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,952,140.25</b>	<b>1,077,906.34</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,952,140.25	1,077,906.34
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>3,018,800.00</u></b>	<b><u>4,938,450.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>3,018,800.00</u></b>	<b><u>4,938,450.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>3,018,800.00</u></b>	<b><u>4,938,450.00</u></b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,018,800.00</b>	<b>4,938,450.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,018,800.00	4,938,450.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-3,018,800.00</u></b>	<b><u>-4,938,450.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**СТ-4А**  
/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	190,149,470.50	579,519,896.06	132,947,657.40	902,617,023.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	321,762.00	321,762.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	190,149,470.50	579,519,896.06	133,269,419.45	902,938,785.96
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-321,762.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-25,921,412.84	-25,921,412.84

**Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	190,149,470.50	579,198,134.06	107,348,006.56	876,695,611.12
D01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	190,149,470.50	579,198,134.06	107,348,006.56	876,695,611.12
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	190,149,470.50	579,198,134.06	107,348,006.56	876,695,611.12
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	268,430,500.26	268,430,500.26
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	190,149,470.50	579,198,134.06	375,778,506.82	1,145,126,111.38

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

ТГ

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	470,313,200.00	462,130,825.48
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	470,313,200.00	462,130,825.48
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	470,313,200.00	462,130,825.48
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	303,513,600.00	298,693,025.47
210101	Үндсэн цалин	188,656,900.00	188,656,900.00
210102	Нэмэгдэл	82,947,400.00	79,143,803.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,313,000.00	4,221,214.60
210104	Урамшуулал	26,596,300.00	26,671,107.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	40,974,200.00	39,194,338.19
210201	Тэтгэврийн даатгал	28,833,700.00	28,739,596.26
210202	Тэтгэмжийн даатгал	3,035,200.00	2,743,081.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,428,100.00	1,802,642.73
210204	Ажилгүйдлийн даатгал	607,000.00	601,794.79
210205	Эрүүл мэндийн даатгал	6,070,200.00	5,307,222.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	37,466,000.00	36,823,291.82
210301	Гэрэл, цахилгаан	2,543,200.00	2,101,061.82
210302	Түлш, халаалт	34,522,800.00	34,522,730.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	199,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	30,239,700.00	29,759,925.00
210401	Бичиг хэрэг	2,200,000.00	2,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,273,700.00	22,271,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,016,000.00	1,541,800.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	300,000.00

**Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,497,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	950,000.00	949,025.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>45,450,700.00</b>	<b>45,415,790.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36,640,700.00	36,639,490.00
210502	Хоол, хүнс	6,300,000.00	6,266,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,510,000.00	2,510,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,850,000.00</b>	<b>4,817,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,850,000.00	2,817,800.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,999,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>897,300.00</b>	<b>506,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	897,300.00	506,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>450,000.00</b>	<b>450,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6471700.00</b>	<b>6471355.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,471,700.00	6,471,355.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>470,313,200.00</b>	<b>462,130,825.48</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>411,183,300.00</b>	<b>410,105,393.66</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	411,183,300.00	410,105,393.66
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>37,966,000.00</b>	<b>37,323,291.82</b>
132001	Орон нутгийн төсвөөс	37,966,000.00	37,323,291.82
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>21,163,900.00</b>	<b>14,702,140.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,163,900.00	14,702,140.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>22.00</b>	<b>22.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>22.00</b>	<b>22.00</b>
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	17.00	17.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	05.00	05.00

**2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

НТ-2

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,858,234.00</b>	<b>155,254,880.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,858,234.00</b>	<b>155,254,880.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,828,700.00</b>	<b>155,254,880.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,828,700.00</b>	<b>155,254,836.78</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,828,700.00	155,254,836.78

**Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4,029,534.00	43.22
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,029,534.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,029,534.00	00.00
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>43.22</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	43.22
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	155,254,880.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	5,858,234.00	155,254,880.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,940,134.00	53,459,880.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,918,100.00	00.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	101,795,000.00
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Заг сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Эрүүл мэндийн төвийн эрхлэгч О.Гэрэлчимэг нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Ж.Дааханжав хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Заг сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд нь хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тасралтгүй зарчмаар стандартын дагуу чанартай тэгш шударга үзүүлэх, иргэдийн эрүүл мэндийг сайжруулахад үйлчлүүлэгчдэдээ хамгийн ээлтэй

тусламж үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагаар үнэлэгдэж иргэдэд хүргэх зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Заг сумын Эрүүл мэндийн салбарын хэмжээнд мөрдөх холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 435664,6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6534.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4901.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 7062.6 мянган төгрөг буюу 2161.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь Ковид -19 цар тахалтай холбоотой нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМД-ын санхүүжилтийн 155254.9 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан, ЭМДС-гийн дутуу санхүүжилтийн 178290.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч авлага үүссэнтэй холбоотой тул өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1145126.1 мянган төгрөг болж өмнөх оноос 262,632.8 мянган төгрөгөөр буюу 29,8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, тусгай зориулалтын материал, эм, ороох боох материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	28,343.3	223,579.8	195,236.5
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	140.2	180,195.2	180,054.9
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	28,203.0	43,384.7	15,181.6
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	854,150.1	921,546.3	67,396.2
Үндсэн хөрөнгө	1,001,182.2	1,092,704.5	91,522.3
Хуримтлагдсан элэгдэл	(147,032.2)	(171,158.2)	(24,126.1)
<b>Нийт хөрөнгө</b>	882,493.3	1,145,126.1	262,632.8
Өр төлбөр	5,797.7	-	(5,797.7)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	876,695.6	1,145,126.1	268,430.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	882,493.3	1,145,126.1	262,632.8

Эх сурвалж : 2021 оны санхүүгийн тайлангаас авав.

Авлага дансны үлдэгдэл 180,195.2 мянган төгрөг болж 180,054.9 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 өвчлөлийн эмчилгээний төлбөрийн санхүүжилт бүрэн орж ирээгүйгээс шалтгаалсан ба үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 43384.7 мянган төгрөг болж 15181.6 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 10094.0 мянган төгрөгөөр , эм, ороох боох материалын дансны үлдэгдэл 8660.8 мянган төгрөг болж 6239.3 мянган төгрөгөөр тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна. Энэ нь Ковид -19 цар тахалтай холбоотой хамгаалах хэрэгсэл, эмийн нөөцийг нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1092704.5 мянган төгрөг болж 91522.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 3288.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, 46659.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө ЭМГ-аас үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн, 300.0 мянган төгрөгөөр ном худалдан авсан, аймгийн ОНХС-гийн эх үүсвэрээр 39924.3 мянган төгрөгийн дээврийн их засварын ажил хийгдсэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1145126.1 мянган төгрөг болж 268430.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн системийн байгууллагууд төсвийн төлөвлөлтийг хийхдээ цалингийн зардал, тогтмол зардлын төсвийг төлөвлөж, бусад суурь үзүүлэлтийг ЭМГ-т хүргүүлдэг ба системийн дээд байгууллага нь нэг иргэнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөдөг ба тайлант онд 470813.2 мянган төгрөгийг зарцуулах төсөв батлагдсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 470313.2 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 411183.3 мянга, орон нутгийн төсвөөс 37966.0 мянга, ЭМДС-гаас 21163.9 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 411183.3 мянга, орон нутгийн төсвөөс 37323.3 мянга, ЭМД-аас 14702.1 мянга, нийт 463208.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 462130.8 мянган төгрөгийг зарцуулж 1077.9 мянган төгрөг буюу 0,2 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 642.7 мянган төгрөгөөр, ЭМД-аас авах санхүүжилтийг 6461.8 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 462130.8 мянган төгрөг буюу 98,3 хувьтай байгаа нь байр ашиглалттай тогтмол зардлыг 642.7 мянга, цалин, хөлс болон нэмэгдэл урамшуул, ажил олгогчоос төлөх НДШ-ийг 6600.5 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна. Цалин хөлсний зардал хэмнэгдсэн нь эмчлэгч эмчийн орон дутуу ажилласнаас шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 155254.9 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан байна. Нийт төвлөрсөн орлогын 101795.0 мянган төгрөг нь Ковид-19 цар тахлын эмчилгээний төлбөрөөс орсон орлого байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа ЭМЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор ажилласан.

Ковид-19 цар тахлын хүрээнд СОК-ын шийдвэрийн дагуу тусгаарлан ажиглах 48 ортой байрыг сургууль, ЗДТГ-ын буудал зэрэгт бэлтгэсэн. Өөрийн халдвартын эмнэлгийг тусгаарлан эмчлэх эмнэлэг буюу улаан бүс болгож 10 ортойгоор дэлгэж, хуваарийн дагуу эмч сувилагч үйлчлэгч гэсэн бүрэлдэхүүнтэй тусгаарлан эмчлэх эмнэлэгтээ 7-14 хоногийн хугацаатай ажиллаж тусламж үйлчилгээгээ үзүүлсэн. Нийт 347 өвчтөнийг хэвтэн эмчлүүлсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Энхтуяа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт 32 ажлыг тусган хэрэгжилтийг ханган ажилласан хэрэгжилт 90%-тай гэж тайлагнасан .

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 627788.5 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 192123.9 мянган төгрөгөөр буюу 44,1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь нормативд зардал 20365.1 мянган , бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардал 136193.2 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл , мэдээлбэл зохих 149 мэдээллээс сар бүр мэдээлэх Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын 41250.6 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 1 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын 9 дүгээр сарын 107918.6 мянган төгрөгийн үнийн дүнтэй 1, нийт 149,169.2 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 2 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### 3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа нь тусгай чиг үүрэг бүхий байгууллага тул дээрх тогтоолд хамаарахгүй болно.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр шатах тослох материал, хүнсний материал худалдан авах ажиллагааг Сумын Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын А/29, А/31 дугаар бүхий захирамжуудаар НИК ХХК, “Бүүвэй ус” ХХК-тай шууд гэрээ байгуулсан байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Зөрчилгүй санал дүгнэлт авсан. Аудитаар нийт 1316,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, төлбөрийн акт тогтоосон ба зөрчлийг арилгах 1 зөвлөмж өгөгдсөн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 37 тоот, 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 64 тоот албан бичгээр тус тус ирүүлсэн.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацаанд ЭМД-аас авах санхүүжилтийн 178290.0 мянган төгрөгийн авлага үүссэн ба цаашид өглөг авлагын тооцоог тухайн онд нь багтаан шийдвэрлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,701.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 785.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1916.0 мянган төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлээ.

### 4.1 Төлбөрийн акт

4.1.1. Сумын Засаг даргын 2021.03.18-ны А/47 дугаар бүхий захирамжаар ЭМТ-ийн эмчлэгч эмчийн сул орон тооны ажлыг ЭМТ-ийн даргад түр хавсран гүйцэтгүүлсэн байна. Гэтэл ЭМТ-ийн даргын 2021.07.09-ний 35 дугаар тушаалаар эмчлэгч эмчээр Н.Ариунчимэгийг 2021.07.01-ний өдрөөс түр томилсон байхад О.Гэрэлчимэгт эмчлэгч эмчийн ажил хавсарсны нэмэгдэлд 7,8,9-р саруудад 785,6 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3.санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх; 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхээр төлөвлөж, зарцуулах; , санхүүгийн тайлагналын “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Холбогдох ажилтнаар 785.6 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 4.2. Залруулсан алдаа

4.2.1. 2021 оны 6-р сард аймгийн Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн анхан шатны баримттай 1916.0 мянган төгрөгийн автомашины 4ш дугуй, бусад хамгаалах хэрэгслийн хөдөлгөөний тайланг нярав гаргаагүй байв.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Анхан шатны баримтыг үндэслэн нярвын аж ахуйн материалын тайланд 1,916.0 мянган төгрөгийн орлого авхуулж, зарлагадуулан тайланг залруулав.

## 4.2 Зөвлөмж

4.2.1 Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс сар бүр мэдээлэх Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын 41250.6 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 1 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын 9 дүгээр

**Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

сарын 107918.6 мянган төгрөгийн үнийн дүнтэй 1, нийт 149169,2 мянган төгрөгийн 2 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар 6.3.2.төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.3.2, 6.4.5 дахь хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Заг сумын Эрүүл мэндийн төв	3	2,701.6	1	1,916.0	1	785.6	0	0.0	1	

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_